

ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргах, судалгаа явуулах зорилгоор “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд шинэчлэн баталснаар хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс тооцож байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдийг 2009 он хүртэл аймаг, нийслэлийн засаг захиргааны анхан шатны нэгжээс мэдээлдэг “Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан”-гийн дүнгээр гаргаж байсан.

Монгол улсад “Ажиллах хүчний судалгаа”-г 2002-2003 онд анх удаа олон улсын нийтлэг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон. Харин “Статистикийн тухай” Монгол улсын хуулинд 2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2006 оноос эхлэн “Ажиллах хүчний судалгаа”-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархаадаг болсон.

Ажиллах хүчний судалгаанд нийслэлийн 9 дүүргээс түүврээр сонгогдсон өрхөөс мэдээллийг сар бүр цуглуулж, улирлаар нэгтгэж, үр дүнг гаргадаг.


Шинэчлэн батлагдсан аргачлалын дагуу ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцож гаргаснаар 2016 онд улсын хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 1275.7 мянга байгаагийн 39.7 хувь, хөдөлмөр эрхэлж буй 1147.8 мянган ажиллагчид байгаагийн 40.5 хувь нь тус тус нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилах бөгөөд энд танилцуулж буй мэдээллийг эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амаар гаргасан болно.

Хүснэгт 1. Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, 2011-2016 он

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	710,259	735,759	845,487	870,776	917,814	981,432
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	382,810	393,321	447,293	476,138	494,106	511,509
Үүнээс: Ажиллагчдын тоо	361,404	365,287	426,731	451,819	459,971	465,091
Ажилгүй иргэдийн тоо	21,406	28,034	20,562	24,319	34,135	46,418
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	29,331	12,811	14,143	15,787	12,640	11,988
Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо	327,449	342,438	398,194	394,638	423,708	469,923
Ажиллах хүчний оролцооны түвшин	53.9	53.5	52.9	54.7	53.8	52.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	50.9	49.6	50.5	51.9	50.1	47.4
Ажилгүйдлийн түвшин	5.6	7.1	4.6	5.1	6.9	9.1

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг ажиллах хүчний оролцооны түвшин 52.1 хувьтай байна. Ажиллах хүчний судалгааны тооцоогоор 2016 онд эдийн засгийн идэвхтэй хүн ам 511.5 мянга байгаагаас 465.1 мянга буюу 90.9 хувь нь ажиллагчид, 46.4 мянга буюу 9.1 хувь нь ажилгүй иргэд байна.

Зураг 1. Хүн амын хөдөлмөр эрхлэлт



Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарт ажиллагсдын тоо 2010 онд 360.9 мянга, 2011 онд 361.4 мянга, 2012 онд 365.3 мянга, 2013 онд 426.7 мянга, 2014 онд 451.8 мянга, 2015 онд 460.0 мянга, 2016 онд 465.1 мянга болжээ. Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин

хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзсэн.

Хүснэгт 2. Ажиллагчдын тоо, дүүргээр, 2011-2016 он

Дүүрэг	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ажиллагчид, бүгд	361,404	365,287	426,731	451,819	459,971	465,091
Багануур, Багахангай	8,975	10,691	9,627	10,034	10,303	9,240
Баянгол	57,937	60,585	76,371	76,121	71,626	72,082
Баянзүрх	86,492	87,698	107,637	103,001	109,583	125,044
Налайх	9,616	9,074	10,782	11,831	14,614	13,840
Сонгинохайрхан	79,548	71,335	87,092	103,318	107,105	104,512
Сүхбаатар	46,273	44,925	45,120	47,247	46,778	40,530
Хан-Уул	37,393	33,478	43,076	52,088	53,318	55,488
Чингэлтэй	35,170	47,501	47,026	48,179	46,644	44,355

Зураг 2. Ажиллагчдын тоо, дүүргээр



Ажиллах хүчний судалгааны дүнгээр нийт ажиллагчдын 26.9 хувь буюу 125,044 нь Баянзүрх дүүрэгт 22.5 буюу 104,512 нь Сонгинохайрхан дүүрэгт, 15.5 хувь буюу 72,082 нь Баянгол дүүрэгт, 11.9 хувь буюу 55,488 нь Хан-Уул дүүрэгт, 9.5 хувь буюу 44,355 нь Чингэлтэй дүүрэгт, 8.7 хувь буюу 40,530 нь Сүхбаатар дүүрэгт, 3.0 хувь буюу 13,840 нь Налайх дүүрэгт, 2.0 хувь буюу 9,240 нь Багануур, Багахангай дүүрэгт байна.

Багахангай дүүргийн хувьд хүн амын тоо цөөн учир судалгааны түүвэрлэлт хийхдээ Багануур дүүрэгтэй нэгтгэн түүврийн нэгж болгосон тул үр дүнг тооцож гаргахад Багануур, Багахангай дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт нэгдсэн байдлаар гарсан болно.


Ажиллах хүчний судалгааны дүнгээр ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулан тооцсон ажилгүйдлийн түвшин 9.1 хувь болж өмнөх оноос 2.2 пунктээр өссөн байна. Ажилгүй иргэн гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

Хүснэгт 3. Ажилгүй иргэдийн тоо, дүүргээр, 2011-2016 он

Дүүрэг	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ажилгүй иргэд, бүгд	21,406	28,034	20,562	24,319	34,135	46,418
Багануур, Багахангай	2,831	744	1,717	1,272	516	340
Баянгол	5,603	4,188	5,230	5,273	6,161	8,716
Баянзүрх	3,402	6,660	2,792	2,499	6,983	7,732
Налайх	882	887	154	114	2,309	1,531
Сонгинохайрхан	1,999	3,901	3,739	4,782	6,840	10,674
Сүхбаатар	1,710	3,216	1,333	3,604	2,084	4,159
Хан-Уул	1,875	3,170	1,397	3,070	3,680	5,757
Чингэлтэй	3,104	5,268	4,200	3,705	5,562	7,509

2016 оны байдлаар ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцсон ажилгүйдлийн түвшин Орхон аймагт хамгийн өндөр буюу 22.4 хувь, Төв аймагт хамгийн бага буюу 2.7 хувь байгаа бол нийслэл Улаанбаатар хотод 9.1 хувьтай байгаа нь улсын дунджаас 0.9 пунктээр доогуур байна.

Зураг 3. Ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний судалгааны дүнгээр, 2016 он



Нийт ажиллагчдын 22.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 11.2 хувь нь барилгын, 10.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 8.6 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 8.4 хувь нь боловсролын, 7.5 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалалах салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж байна.


Хүснэгт 4. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Үүнээс: Эмэгтэй
Ажиллагчид, бүгд	361,404	365,287	426,731	451,819	459,971	465,091	216,679
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8,679	10,872	9,181	9,348	7,995	14,683	5,607
Уул уурхай, олборлолт	15,299	19,364	23,570	18,673	18,236	16,095	1,870
Боловсруулах үйлдвэрлэл	34,419	34,785	47,416	52,754	48,114	49,630	23,770
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	5,009	7,077	5,467	7,085	7,191	7,468	1,614
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2,749	2,892	3,777	4,483	3,542	2,770	1,768
Барилга	34,252	37,571	48,396	57,825	60,682	51,916	10,210
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	82,510	72,893	89,275	95,526	99,031	103,422	56,657
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	43,751	30,816	36,929	39,233	42,213	40,215	9,217
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	16,498	18,872	17,807	22,927	22,390	19,325	13,850
Мэдээлэл, холбоо	8,306	10,556	12,815	13,803	12,205	14,262	5,778
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	9,215	9,649	12,456	14,305	13,263	12,983	8,089
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	205	905	616	885	733	767	367
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6,333	5,998	8,164	7,566	8,581	8,234	3,788
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7,380	9,896	11,401	9,048	12,952	12,287	4,770
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	20,298	26,388	27,208	30,049	31,024	34,774	14,886
Боловсрол	32,680	32,441	33,308	33,740	33,718	39,130	30,396
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	16,276	16,339	18,652	17,872	18,327	18,822	14,576
Урлаг, үзвэр, тоглоом наадам	4,027	3,203	5,032	4,610	7,281	5,870	2,924
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11,583	11,418	13,009	10,535	10,951	11,317	6,244
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	325	526	635	355	430	393	73
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1,610	2,826	1,617	1,197	1,112	728	225

Нийт ажиллагчдын 46.6 хувь буюу 216,679 нь эмэгтэй байгаа бөгөөд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, зочил буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, боловсролын зэрэг салбарт эрэгтэй ажиллагчдаас

илүү ажиллаж байгаа бол, уул уурхай, олборлолт, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, барилга, цахилгаан, хий, уур, агааржуулалт, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа зэрэг салбарт эмэгтэйчүүдийн оролцоо бага байна.

Зураг 4. Ажиллагчдын тоо, үйл ажиллагааны салбарын ангиллаар



2016 онд уул уурхай, олборлолт, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, зочид бүүдал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, удирдлагын болон

дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо 2015 оноос буурч, харин бусад салбарт ажиллагчдын тоо өсчээ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар улсын дүнд хамгийн бага буюу 4.2 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, хамгийн их буюу 100.0 хувийг үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт ажиллагчид эзэлж байна.

Хүснэгт 5. Ажиллагчдын тоо, аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр

Хариуцлагын хэлбэр	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ажиллагчид, бүгд	361,404	365,287	426,731	451,819	459,971	465,091
Компани	147,653	166,335	200,134	220,485	226,323	237,028
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	119,094	95,394	124,564	119,362	118,176	112,723
Төсөвт байгууллага	74,949	72,028	77,676	81,743	84,216	86,194
Улсын үйлдвэрийн газар	11,252	19,970	17,101	19,390	21,066	20,121
Нөхөрлөл	1,132	832	138	363	1,140	957
Хоршоо	366	954	798	1,701	1,449	1,514
Төрийн бус байгууллага	6,958	9,774	6,320	8,775	7,601	6,554

2016 оны байдлаар нийслэл хотод ажиллагчдыг ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр нь ангилбал 51.0 хувь буюу 237,028 нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани, 24.3 хувь буюу 112,723 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 18.5 хувь буюу 86,194 нь төсөвт, 4.3 хувь буюу 20,121 нь төрийн өмчит болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 0.2 хувь буюу 957 нь нөхөрлөл, 0.3 хувь буюу 1,514 нь хоршоо, 1.4 хувь буюу 6,554 нь төрийн бус байгууллагад тус тус ажиллаж байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

Хөдөлмөр эрхлэлтийн статус	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ажиллагчид, бүгд	361,404	365,287	426,731	451,819	459,971	465,091
Цалин хөлстэй ажиллагч	231,169	265,045	295,211	312,161	321,407	340,286
Ажил олгогч	9,454	4,990	8,281	10,691	8,342	11,657
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	107,145	80,368	107,475	111,269	116,248	87,996
Мал аж ахуй эрхлэгч	5,754	5,213	4,923	6,164	4,694	9,994
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	7,591	8,987	10,715	11,008	9,158	15,074
Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч	291	684	126	526	122	84

2016 оны байдлаар ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь ангилбал 73.2 хувь буюу 340,286 нь цалин хөлстэй ажиллагч, 2.5 хувь буюу 11,657 нь ажил олгогч, 18.9 хувь буюу 87,996 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2.2 хувь буюу 9,994 нь мал аж ахуй эрхлэгч, 3.2 хувь буюу 15,074 нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байна.

Зураг 5. Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар



Хүснэгт 7. Ажиллагчдын тоо, насны бүлгээр

Насны бүлэг	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ажиллагчид, бүгд	361,404	365,287	426,731	451,819	459,971	465,091
15 - 19	4,574	5,358	3,604	4,664	4,497	2,728
20 - 24	38,170	35,937	44,225	43,964	41,718	35,379
25 - 29	56,197	63,763	72,058	75,178	71,374	76,432
30 - 34	56,065	57,426	65,987	67,981	73,906	75,951
35 - 39	61,925	60,244	64,245	81,020	78,806	76,068
40 - 44	50,394	49,566	63,267	62,684	65,961	65,672
45 - 49	49,205	44,813	54,842	53,957	58,064	59,176
50 - 54	28,859	31,222	38,392	41,488	42,530	46,965
55 - 59	10,844	11,955	16,843	14,749	18,001	19,838
60 - 64	2,938	2,650	2,824	3,825	3,498	4,673
65 - 69	962	1,351	387	1,114	1,092	1,753
70 +	1,271	1,002	57	1,195	524	456

2016 оны байдлаар ажиллагчдыг насны бүлгээр нь ангилбал 8.2 хувь буюу 38,107 нь 15-24 насны, 32.8 хувь буюу 152,383 нь 25-34 насны, 30.5 хувь буюу 141,740 нь 35-44 насны, 22.8 хувь буюу 106,141 нь 45-54 насны, 5.7 хувь буюу 26,720 нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 8. Ажиллагчдын тоо, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ажиллагчид, бүгд	361,404	365,287	426,731	451,819	459,971	465,091
Боловсролгүй	1,103	1,672	929	1,102	375	780
Бага	3,647	3,521	2,249	2,384	3,548	3,281
Суурь	27,031	21,566	21,491	14,527	16,390	13,177
Бүрэн дунд	135,329	115,478	96,598	54,709	58,157	57,158
Техникийн болон мэргэжлийн	24,468	31,404	81,344	143,832	144,350	154,769
Тусгай мэргэжлийн дунд	17,644	25,382	28,318	36,925	28,613	25,905
Дипломын дээд болон бакалавр	145,306	148,271	182,027	184,139	194,033	191,729
Магистр ба түүнээс дээш	6,876	17,993	13,775	14,202	14,505	18,292

2016 оны байдлаар ажиллагчдыг боловсролын түвшнээр нь авч үзвэл 0.2 хувь буюу 780 нь боловсролгүй, 0.7 хувь буюу 3,281 нь бага, 2.8 хувь буюу 13,177 нь суурь боловсролтой, 12.3 хувь буюу 57,158 нь бүрэн дунд, 33.3 хувь буюу 154,769 нь техникийн болон мэргэжлийн, 5.6 хувь буюу 25,905 нь тусгай дунд, 41.2 хувь буюу 191,729 нь дипломын дээд болон бакалавр, 3.9 хувь буюу 18,292 нь магистр ба түүнээс дээш боловсролтой иргэд байна.

2016 оны байдлаар нийслэл хотод эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 469.9 мянга болжээ. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа б сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулсан.

Хүснэгт 9. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, дүүргээр, 2011-2016 он


Дүүрэг	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	327,449	342,438	398,194	394,638	423,708	469,923
Багануур, Багахангай	9,673	11,300	11,038	12,447	12,715	14,780
Баянгол	49,650	52,527	61,872	56,158	61,283	69,644
Баянзүрх	70,638	74,897	95,980	96,472	97,062	106,658
Налайх	12,977	10,219	12,646	11,422	9,256	10,592
Сонгинохайрхан	75,771	72,245	85,861	93,226	100,717	112,248
Сүхбаатар	41,198	43,430	43,123	40,303	44,303	47,700
Хан-Уул	31,462	33,767	42,862	38,187	45,918	53,410
Чингэлтэй	36,080	44,053	44,812	46,423	52,454	54,891

Эдийн засгийн идэвхгүй хүн амаас суралцдаг, сурахаар явах гэж байгаа, тэтгэврийн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн нас хүрээгүй иргэдийг хасвал 161.4 мянган иргэн ямар нэг шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 10. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, шалтгаанаар, 2011-2016 он

Шалтгаан	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	327,449	342,438	398,194	394,638	423,708	469,923
Гэрийн ажилтай	28,417	34,640	32,640	32,977	30,523	33,490
Суралцдаг	122,061	112,807	130,050	130,353	132,504	135,782
Сурахаар явах гэж байгаа	1,945	1,658	1,630	2,372	2,759	3,843
Тэтгэвэрт	69,098	74,865	88,665	111,970	122,151	119,314
Өндөр настан	7,747	15,902	19,220	2,561	3,155	17,275
Хөгжлийн бэрхшээлтэй	20,567	22,577	26,155	28,442	30,632	32,078
Ажил хийхийг хүсээгүй	5,417	5,674	8,060	7,015	6,493	6,114
Хүүхэд асарсан	39,163	34,440	52,894	49,325	61,614	73,269
Өвчтэй байсан	7,168	8,269	8,542	7,199	6,640	10,207
Хөдөлмөрийн нас хүрээгүй	47	122	136	-	153	248
Өвчтөн, өндөр настан асарсан	3,800	4101	4,409	4,186	5,643	6,476
Бусад	22,019	27,383	25,793	18,238	21,441	31,826

Зураг 6. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, шалтгаанаар



Хөдөлмөр эрхлээгүй дээрх 161.4 мянган иргэний 20.8 хувь гэрийн ажилтай, 3.8 хувь нь ажил хийхийг хүсээгүй, 45.4 хувь нь хүүхэд асардаг, 6.3 хувь нь өөрөө өвчтэй байсан, 4.0 хувь нь өвчтөн, өндөр настан асардаг, 19.7 хувь нь бусад шалтгааны улмаас хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 11. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, шалтгаан, дүүргээр, 2016 он

Шалтгаан	Багануур, Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрх ан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Нийслэлийн дун
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд /мян.хүн/	14.8	69.6	106.7	10.6	112.2	47.7	53.4	54.9	469.9
Гэрийн ажилтай	2.1	3.2	9.4	0.4	9.1	3.4	2.9	3.0	33.5
Суралцдаг	4.4	20.4	32.1	3.4	31.4	13.2	17.8	13.1	135.8
Сурахаар явах гэж байгаа	0.1	0.5	1.0	0.2	0.9	0.2	0.4	0.5	3.8
Тэтгэвэрт	3.3	20.5	23.6	2.4	26.2	12.3	13.8	17.2	119.3
Өндөр настан	0.3	2.6	2.0	0.4	4.9	3.6	1.3	2.2	17.3
Хөгжлийн бэрхшээлтэй	0.9	4.3	6.5	1.1	8.0	2.0	4.2	5.1	32.1
Ажил хийхийг хүсээгүй	-	1.2	1.7	0.1	0.6	0.7	1.1	0.7	6.1
Хүүхэд асарсан	1.5	12.0	19.5	1.8	17.2	7.2	7.8	6.3	73.3
Өвчтэй байсан	0.2	0.9	2.7	0.5	2.2	1.2	0.6	1.9	10.2
Хөдөлмөрийн нас хүрээгүй	-	-	0.1	-	-	0.1	-	-	0.2
Өвчтөн, өндөр настан асарсан	0.3	0.6	1.1	0.3	1.8	0.8	0.7	0.9	6.5
Бусад	1.7	3.4	7.0	-	9.9	3.0	2.8	4.0	31.8

Хүснэгт 12. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, насны бүлгээр, 2011-2016 он

Насны бүлэг	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	327,449	342,438	398,194	394,638	423,708	469,923
15 - 19	79,495	75,717	87,234	89,789	91,796	98,152
20 - 24	64,175	61,518	68,151	60,964	59,031	63,054
25 - 29	26,593	27,571	32,323	29,823	36,950	39,261
30 - 34	20,480	20,963	25,020	21,146	26,248	34,082
35 - 39	16,580	17,722	21,487	21,080	23,681	26,384
40 - 44	13,120	13,118	16,868	16,300	18,471	24,392
45 - 49	14,221	14,986	15,768	17,530	16,857	21,210
50 - 54	18,066	19,530	20,328	25,200	25,062	25,833
55 - 59	19,134	22,211	28,926	31,992	37,729	39,289
60 - 64	17,265	23,282	25,201	27,919	30,434	39,055
65 - 69	14,395	16,931	19,196	19,245	22,441	22,836
70 +	23,925	28,889	37,692	33,650	35,008	36,375

2016 оны байдлаар эдийн засгийн идэвхгүй хүн амыг насны бүлгээр нь ангилбал 34.3 хувь буюу 161,206 нь 15-24 насны, 15.6 хувь буюу 73,343 нь 25-34 насны, 10.8 хувь буюу 50,776 нь 35-44 насны, 10.0 хувь буюу 47,043 нь 45-54 насны, 29.3 хувь буюу 137,555 нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 13. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, насны бүлэг, дүүргээр, 2016 он

Насны бүлэг	Багануур, Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Нийслэлийн дүн
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд /мян.хүн/	14.8	69.6	106.7	10.6	112.2	47.7	53.4	54.9	469.9
15 - 19	3.1	12.9	21.0	2.6	26.3	9.3	13.2	9.8	98.2
20 - 24	2.2	9.0	16.9	1.3	14.0	5.6	7.0	7.0	63.0
25 - 29	1.2	5.4	10.8	0.8	10.2	3.4	4.9	2.6	39.3
30 - 34	0.9	4.4	9.5	0.7	8.2	3.6	3.2	3.5	34.0
35 - 39	1.0	3.7	5.7	0.7	6.4	3.3	2.7	2.9	26.4
40 - 44	0.8	4.2	6.1	0.3	5.0	2.9	2.5	2.6	24.4
45 - 49	0.9	3.4	4.4	0.5	6.1	1.8	1.4	2.7	21.2
50 - 54	1.0	3.7	6.5	0.5	4.8	2.1	3.5	3.7	25.8
55 - 59	1.3	6.5	8.6	1.2	7.8	2.7	5.5	5.7	39.3
60 - 64	1.0	5.3	6.4	0.5	12.2	4.5	3.6	5.6	39.1
65 - 69	0.4	4.8	3.8	0.4	4.6	3.9	2.3	2.6	22.8
70 +	1.0	6.3	7.0	1.1	6.6	4.6	3.6	6.2	36.4

Албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хөдөө аж ахуйн бус бөгөөд хуулиар хориглоогүй ажил үйлчилгээ эрхэлж буй иргэдийг албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид гэнэ.

Хүснэгт 14. Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид ,насны бүлэг, хүйсээр, 2016 он

Насны бүлэг	Үндсэн	Үүнээс:		Давхар	Үүнээс:	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, бүгд	80,889	49730	31,159	499	179	320
15 - 19	154	154	-	-	-	-
20 - 24	3,219	2,142	1,077	76	76	-
25 - 29	7,824	5,659	2,165	120	-	120
30 - 34	9,844	6,328	3,516	-	-	-
35 - 39	13,921	9,207	4,714	200	-	200
40 - 44	17,569	9,941	7,628	-	-	-
45 - 49	13,418	7,277	6,141	-	-	-
50 - 54	10,130	5,927	4,203	103	103	-
55 - 59	4,006	2,700	1,306	-	-	-
60 - 64	502	395	107	-	-	-
65 - 69	205	-	205	-	-	-
70 +	97	-	97	-	-	-

2016 оны байдлаар албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг насны бүлгээр нь ангилбал 4.2 хувь буюу 3,373 нь 15-24 насны, 21.8 хувь буюу 17,668 нь 25-34 насны, 38.9 хувь буюу 31,490 нь 35-44 насны, 29.1 хувь буюу 23,548 нь 45-54 насны, 6.0 хувь буюу 4,810 нь 55-аас дээш насны хүмүүс байна. 30-49 насны эрэгтэйчүүдийн хувьд албан бус хөдөлмөр эрхлэлт өндөр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд 35-44 насныханд өндөр байна.

Хүснэгт 15. Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2016 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Үндсэн	Үүнээс:		Давхар	Үүнээс:	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллагчид, бүгд	80889	49730	31159	499	179	320
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	-	-	-	103	103	-
Уул уурхай, олборлолт	95	95	-	-	-	-
Боловсруулах үйлдвэрлэл	10437	5433	5004	120	-	120
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	391	246	145	-	-	-
Барилга	3424	2298	1126	276	76	200
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	37516	19178	18338	-	-	-
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	18639	17773	866	-	-	-
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1567	594	973	-	-	-
Мэдээлэл, холбоо	519	255	264	-	-	-
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	77	-	77	-	-	-
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	586	433	153	-	-	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	720	574	146	-	-	-
Боловсрол	110	-	110	-	-	-
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	269	-	269	-	-	-
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1141	682	459	-	-	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5202	2047	3155	-	-	-
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	196	123	73	-	-	-

Нийт албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчидийн 46.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 23.0 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 12.9 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 6.4 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 4.2 хувь нь барилгын салбарт ажиллаж байна.

Нийт ажиллагчдын 38.5 хувь буюу 31,159 нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, мэдээлэл, холбооны салбарт эрэгтэй ажиллагчдаас илүү ажиллаж байгаа бол, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, боловсруулах үйлдвэрлэл, урлаг, үзвэр, тоглоом наадам, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, барилга, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, удирдлагын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт эмэгтэйчүүдийн ажиллах оролцоо бага байна.

Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэдийн 34.8 хувь буюу 11,988 нь Улаанбаатар хотод амьдарч байна. Нийт ажилгүйчүүдийн 6062 буюу 50.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 16. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр, боловсролын түвшнээр, бүгд

Насны бүлэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
15-24	2,095	6,306	3,354	5,631	4,325	2,456	1,591
25-34	2,962	10,011	4,543	4,059	6,012	4,965	4,783
35-44	2,111	7,460	2,809	2,294	2,889	2,873	3,066
45+	1,920	5,554	2,105	2,159	2,561	2,346	2,548
Дээд боловсролтой	2,060	6,955	5,041	5800	6,422	4,595	5,238
Тусгай дунд боловсролтой	502	2,486	950	1423	1,071	822	747
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгссөн	387	1,989	918	750	851	611	583
Мэргэжилгүй	6,139	17,901	5,902	6170	7,443	6,612	5,420
Ажилгүй иргэд /нийслэл/	9,088	29,331	12,811	14,143	15,787	12,640	11,988
Ажилгүй иргэд /улсын дүн/	38,250	57,171	35,776	42,772	36,970	32,788	34,412
Улсын дүнд эзлэх хувь	23.8	51.3	35.8	33.1	42.7	38.6	34.8

Хүснэгт 17. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр, эмэгтэй

Насны бүлэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
15-24	906	2,875	1,836	3,201	2,571	1,297	788
25-34	1,487	3,911	2,540	2,276	3,509	2,872	2,526
35-44	1,124	3,232	1,498	1,280	1,518	1,629	1,550
45-59	971	2,766	1,006	1,059	1,174	1,121	1,198
Ажилгүй иргэд /нийслэл/	4,488	12,784	6,880	7,816	8,772	6,919	6,062
Ажилгүй иргэд /улсын дүн/	20,116	26,043	18,766	23,470	20,459	17,720	17,784
Улсын дүнд эзлэх хувь	22.3	49.1	36.7	33.3	42.9	39.0	34.8

Боловсролын түвшнээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 43.7 хувь буюу 5238 нь дээд, 6.2 хувь буюу 747 нь тусгай дунд, 4.9 хувь буюу 583 нь мэргэжлийн анхан шатны, 44.8 хувь буюу 5375 нь ерөнхий, 0.4 хувь буюу 45 нь мэргэжилгүй хүмүүс байна.

Хүснэгт 18. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, дүүргээр, 2010-2016 он

Дүүрэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Бүртгэлтэй ажилгүй иргэд, бүгд	9,088	29,331	12,811	14,143	15,787	12,640	11,988
Багануур	754	1,616	357	311	418	589	579
Багахангай	434	265	173	77	126	112	134
Баянгол	868	3,689	1,854	2,426	2,489	1,807	1,532
Баянзүрх	1,164	5,742	1,446	2,670	3,290	2,068	2,443
Налайх	219	1,515	1,395	1,266	1,093	642	706
Сонгинохайрхан	2,289	6,951	2,227	2,619	2,197	1,629	2,010
Сүхбаатар	543	2,461	2,729	1,635	1,925	1,844	1,378
Хан-Уул	600	1,745	919	1,027	1,964	1,247	1,509
Чингэлтэй	2,217	5,347	1,711	2,112	2,285	2,702	1,697

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.4 хувь буюу 2443 нь Баянзүрх, 16.8 хувь буюу 2010 нь Сонгинохайрхан, 14.1 хувь буюу 1697 нь Чингэлтэй, 12.8 хувь буюу 1532 нь Баянгол, 12.6 хувь нь буюу 1509 нь Хан-Уул, 11.5 хувь буюу 1378 нь Сүхбаатар, 5.9 хувь буюу 706 нь Налайх, 4.8 хувь буюу 579 нь Багануур, 1.1 хувь буюу 134 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 7. Бүртгэлтэй ажилгүйчүүд, 2004-2016

